

## Улаанбаатар хотын гэр бүлийн амьдралын мөчлөгийн судалгаа

*МУИС-ийн ЭЗС-ийн Хүн ам зүйн 4 дүгээр ангийн оюутан Ж.Мөнхбадар  
Удирдсан багш: МУИС-ийн ЭЗС-ийн ХАССТ-ийн багш Б.Мөнхжаргал*

*Гэр бүлийн амьдралын мөчлөг судлал нь хүн ам зүйн шинжслэх ухааны чухал асуудлуудын нэг юм.*

*Монголд гэр бүлийн амьдралын мөчлөгийг тодорхой хүрээнд судалж байсан ч хүн ам зүйн үзүүлэлтүүдийн өөрчлөлт, хандлагатай холбон судалсан судалгаа, шинжилгээний ажил их дутмаг, хэрэглээ (тухайлбал, нийгэм, эдийн засгийн төлөвлөлт, гэр бүлийн хөгжлийн талаарх аливаа төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэх тал дээр) сүл байна.*

*Энэхүү ажил нь Улаанбаатар хотын гэр бүлийн амьдралын мөчлөгт гарч буй өөрчлөлт, түүний үр нөлөөг судлах зорилготой. Судалгаанд Улаанбаатар хотын төвийн б дүүргийн 45-аас дээши настын нийт 250 эмэгтэйг хамруулсан бөгөөд эх олонлогоос түүвэрлэхдээ магадлалт бус, боломжит түүвэрлэлтийн аргыг ашигласан.*

*Судалгаанд хамрагдсан нийт эмэгтэйчүүдийн гэр бүлийн амьдралын мөчлөгийг тодорхойлоходоо хэд хэдэн загварыг ашигласан бөгөөд судалгааны дүнгээс харахад нийт судалгаанд хамрагдагсдын дийлэнх хувь нь нуклеар өрхөд амьдарч байсан учраас Glick-ийн загварыг гол болгон шинжилгээ хийсэн. Загвар I-д нөхөр нь нас барах үеийн эмэгтэйн насыг тодорхойлоходоо судалгааны асуултыг нэгтгэж тооцсон бол загвар II-т 2000 оны Улаанбаатар хотын насжилтийн хүснэгтийн тухайн наснаас цаашид үргэлжлэн амьдрах хүн жилийн тооцоог ашигласан. Харин сүүлийн III дахь загварт ниймлэл өрхийн хэв шинжийг илүү тусгасан.*

*Судалгаанд хамрагдсдын гэр бүлийн амьдралын мөчлөгийн (Загвар I) I үеийн үргэлжлэх хугацаа нийт эмэгтэйчүүдийн хувьд 1,09 жил, II үе 11,37 жил, III үе 10,03 жил, IV үе 11,04 жил, Y болон YI үе нийтдээ 24,34 жил байна. Үе тус бүрийн үргэлжлэх хугацааг авч үзэхэд I, III, YI үе настын бүлэг залуужих тусам нэмэгдэх хандлагатай байхад II болон IV үеийн хувьд буурах хандлагатай байна.*

*Гэр бүлийн амьдралын мөчлөгийн үе тус бүр нь Монголын хүн ам зүйн түүхэн өөрчлөлт, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсийн нөлөөг тусгаж байв. Тодруулбал, XX зууны эхэн үеийн ядуу буурай байдал, хөгжлийн доогуур түвшин, 1980-аад оноос эхэлсэн төрөлтийн бууралт, зах зээлийн эдийн засагт шилжих үеийн хямрал зэргийг онцолж болно.*

*Хүн ам зүй болон нийгэм, эдийн засагт гэр бүлийн амьдралын мөчлөгийн үе тус бүр нь олон эерэг, сөрөг үр дагаврыг бий болгодог. Эхний үе урт байх нь төрөлтийн түвшин буурахыг, YI үе богино байх нь эмэгтэйчүүдийн хөдөлмөр оролцооны түвшин буурахыг, сүүлчийн үе урт байх нь өрх, эрүүдэд ачаалал нэмэгдэхийг харуулдаг.*

### 1. Үндэслэл

Гэр бүлийн амьдралын мөчлөг судлал нь хүн ам зүйн шинжлэх ухааны чухал асуудлуудын нэг юм. Гэр бүлийн амьдралын мөчлөгийг судлах нь нийгэм талаасаа гэр бүлийн үнэт зүйлс, ёс суртахуун, зан үйл болон хэв шинжийг гаргаж ирдэг. Хүн ам зүйн талаасаа төрөлт, нас баралт болон гэрлэлтийн өөрчлөлт, хандлагын нөлөөг цогц байдлаар нь нэг дор харах боломж олгодог ба эдийн засгийн үүднээс хүний амьдралд жам ёсны өөрчлөлт гарсан (гэрлэх, хүүхэдтэй болох гм) үе бүр дэх өрхийн эдийн засгийн чадавх, боломж, хэрэглээг тодорхойлох бололцоо олгодгоороо нэн ач

холбогдолтой. Түүнчлэн энэ төрлийн судалгаа нь гэр бүлийн амьдралын мөчлөгт нөлөөлөгч хүчин зүйлс болон түүнээс үүдэн гарах хүн ам зүй, нийгмийн үр дагаврыг үнэлэх боломжийг зэрэг олгодгоороо ихээхэн чухалд тооцогддог. Тухайлбал, эмэгтэйчүүдийн хөдөлмөр оролцооны байдал (Oppenheimer 1974), тэтгэвэр, тэтгэмжийн зардал, тэтгэврийн нас (Mann 1990), эмэгтэйчүүдийн боловсролын түвшин (Young 1970), орон сууц болон шилжих хөдөлгөөний асуудлууд, амьдралын мөчлөгийн үе бүрдэх гэрлэлтийн сэтгэл ханамж (Cuisinier 1977), эрүүл мэндийн үйлчилгээний хүргээмж, чанар, гэр бүл төлөвлөлтийн үйлчилгээ (Gove at al. 1973) зэрэг нь гэр бүлийн бүтэц, амьдралын мөчлөгт нөлөөлж байdag ажээ.

Монголд гэр бүлийн амьдралын мөчлөгийг тодорхой хүрээнд судалж байсан ч хүн ам зүйн үзүүлэлтүүдийн өөрчлөлт, хандлагатай холбон судалсан судалгаа, шинжилгээний ажил дутмаг, хэрэглээ сул байгаа (тухайлбал, нийгэм, эдийн засгийн төлөвлөлт, гэр бүлийн хөгжлийн талаарх аливаа төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэх тал дээр) нь энэхүү ажлыг хийх гол үндэслэл болсон. Нөгөөтэйгүүр Монгол Улсын Төрөөс Хүн Амын Хөгжлийн талаар Баримтлах Бодлогод: “хүн амын насны бүтцийн өөрчлөлтөөс үүдэн гарах тулгамдсан асуудлыг хүн амын бүлгийн нас, бие, сэтгэхүй, чадамжийн онцлогт тохирсон, *āyð áčē ḍōâðýé áîäéññā* хэрэгжүүлэх замаар хүний хөгжлийг хангах чиглэл баримтална” гэж заасан байdag. Тиймээс дээрх тулгамдсан асуудлын хүрээнд гэр бүлийн талаар гүнзгийрүүлсэн судалгаа, шинжилгээний өргөн, чанартай ажлуудыг хийх шаардлагатай байна.

## 1.2. Судалгааны зорилго, ач холбогдол, шинэлэг тал

Улаанбаатар хотын гэр бүлийн амьдралын мөчлөгт гарч буй өөрчлөлт, түүний үр нөлөөг энэхүү ажлын хүрээнд судлахыг зорилоо. Зорилгоо хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

- Улаанбаатар хотын өрхийн бүтцийн онцлогийг илрүүлэх;
- Улаанбаатар хотын гэр бүлийн амьдралын мөчлөгийг тодорхойлох;
- Гэр бүлийн амьдралын мөчлөгт гарч буй өөрчлөлтийг судлах;
- Гэр бүлийн амьдралын мөчлөгийн хүн ам зүй, нийгэм, эдийн засагт үзүүлж буй үр нөлөөг гаргах.

Улаанбаатар хотын гэр бүлийн амьдралын мөчлөг, түүнд гарч буй өөрчлөлтүүдийг тодорхойлон гаргаснаар Улаанбаатар хотын гэр бүлийн амьдралын хэв маягийг цогц байдлаар, нэн ялангуяа хүн ам зүй, эдийн засгийн үүдиээс үнэлэх боломж олдоно гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, төрөлт болон гэрлэлт зэрэг хүн ам зүйн үзүүлэлтүүдийн өөрчлөлтөд нөлөөлөгч нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсийг амьдралын мөчлөгтэй нь холбон үзэж, үр дагаврыг нь гаргаж ирэхээрээ бусад ажлуудаас онцлог давуу талтай.

Улаанбаатар хотын гэр бүлийн амьдралын мөчлөгийн судалгаа нь гэрлэлтийн судалгаануудаас анх гэр бүлийн амьдралын мөчлөгийг биээ даасан болон цогц байдлаар, хэд хэдэн үелрэлийг хамруулан шинжилж байгаагаараа шинэлэг гэж хэлж болно.

## 2. Судалгааны арга зүй

### Судалгааны арга, мэдээлийн эх үүсвэр

Гэр бүлийн амьдралын мөчлөгийг тодорхойлохдоо Улаанбаатар хотын өрхүүдийн дунд түүвэр судалгаа хийж анхдагч мэдээлэл цуглуулсан. Энэхүү мэдээллийн үр дүнд тулгуурлан тайлбар статистик болон хүчин зүйлсийн хамаарлын шинжилгээ хийлээ.

### Түүвэр судалгааны арга зүй

Судалгаанд хамрагдагсдыг эх олонлогоос түүвэрлэхдээ магадлалт бус, боломжит түүвэрлэлтийн аргыг ашиглав.

Судалгаанд Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн 45-аас дээш насыны нийт 250 эмэгтэйг хамруулсан болно. Түүврийн тархалтыг насыны бүтцийн хувьд эх олонлогийн насыны тархалттай адил байхаар тооцоолж сонгосон.

Судалгаанд 45-аас дээш насыны эмэгтэй хүн амыг дараах үндэслэлтэйгээр хамруулав.  
Үнд:

- Гэр бүлийн амьдралын мөчлөгийг судлахдаа онолын хувьд эмэгтэй хүн амаар тухайн гэр бүлийг төлөөлүүлж судалдаг;
- Олон улсын түвшинд харьцуулалт хийхдээ эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн амьдралын мөчлөгийн хугацааг 45-49 насаар хязгаарладаг;
- 45-аас дээш насыны эмэгтэйчүүдийн хувьд гэр бүлийн амьдралын мөчлөгийн үеүд нь харьцангуй бүрэн, тодорхой харагддаг байна.

Түүвэр судалгааны мэдээллийг урьдчилан боловсруулсан асуулгаар цуглуулсан бөгөөд мэдээлэл боловсруулалт, шинжилгээнд ISSA болон SPSS судалгааны багц программуудыг ашиглав.

### Судалгааны хэмжигдэхүүн

Судалгааны гол хэмжигдэхүүн нь гэр бүлийн амьдралын мөчлөгийн үе тус бүрийг тодорхойлох зорилго бүхий нас юм. Энэхүү нас нь интервал түвшний хэмжигдэхүүн бөгөөд мөчлөгийг эхийн амьдралын онцлог үе (гэрлэх/хамтран амьдарч эхлэх, хүүхэд төрүүлэх, хүүхэд нь тусдаа гарах г.м)-үүд дэх насаар нь тодорхойлон гаргав.

## 3. Судалгааны үр дүн

### Улаанбаатар хотын өрхийн бүтцийн онцлог

Гэр бүлийн амьдралын мөчлөгийн судалгааны нэг гол хэсэг бол өрхийн бүтцийн талаарх мэдээлэл юм. Нийт судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн өрхийн шинж байдлын үр дүнг Хүснэгт 1-д харуулав.

Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн хувьд өрхийн тэргүүлэгчийн нас дунджаар 52,6 байсан бол үсрэл тус бүрээр бага зэрэг ялгаатай байна. Тухайлбал, 60-аас доош насынхны хувьд өрхийн тэргүүлэгчийн дундаж нас нь тухайн үелрэлийн настай


харьцангуй ойролцоо байгаа бол 60-аас дээш насанд үелрэлийнхээ наснаас илүү залуу байна (Хүснэгт 1). Энэ нь ахимаг насны үелрэлийнхэн хүүхдүүдийнхээ гэрт хамт амьдардагтай холбоотой (60-64 насныхны хувьд 16 орчим хувь нь, 65-69 насныхны 1/4 гаруй нь, 70-аас дээш насныхны хувьд 40 орчим хувь нь хүү/охинихоо гэрт хамт амьдардаг гэж хариулжээ).

*Одийн 1. Эмэгтэйчүүдийн хувийн жин, нас болон өрхийн шинж, байдлаар*

Үзүүлэлтүүд	Насны бүлэг					
	45-49	50-54	55-59	60-64	65-69	70+
Өрхийн тэргүүлэгчийн нас						
20-29	2.7	3.8	4.3	15.4	13.0	10.3
30-39	-	5.8	6.5	11.5	4.3	13.8
40-49	64.9	1.9	2.2	-	8.7	17.2
50-59	31.1	84.6	54.3	7.7	-	17.2
60-69	1.4	3.8	32.6	61.5	43.5	6.9
70+	-	-	-	3.8	30.4	34.5
Дундаж нас	48.34	50.63	54.83	55.08	59.91	55.59
Өрхийн тэргүүлэгчийн хүйс						
Эрэгтэй	78.4	76.9	67.4	80.8	87.0	65.5
Эмэгтэй	21.6	23.1	32.6	19.2	13.0	34.5
Өрхөд амьдарч буй нийт хүний тоо						
2	6.8	11.5	6.5	26.9	13.0	24.1
3	23.0	19.2	21.7	15.4	21.7	17.2
4	23.0	21.2	13.0	23.1	17.4	20.7
5	17.6	19.2	28.3	7.7	17.4	20.7
6+	29.7	28.8	30.4	26.9	30.4	17.2
Дундаж	4.41	4.35	4.54	3.92	4.30	3.90
Өрхийн бүтэц						
Ам бүлээрээ байгаа өрх /нуклесар/	75,7	59.6	41.3	50.0	30.4	27.6
Нийлмэл өрх	24,3	40.4	56.5	50.0	69.6	65.5
Холимог өрх	-	-	2.2	-	-	6.9
Бүгд	100	100	100	100	100	100
Эмэгтэйчүүдийн тоо	74	52	46	26	23	29

Судалгаанаас үзэхэд нэг өрхөд ногдох хүний тоо дунджаар 4.3 гарсан нь 2000 оны Улаанбаатар хотын тооллогын дүн (4.7)-ээс 0.4 пунктээр бага гарчээ. Нэг өрхөд ногдох хүний тоог үелрэл тус бүрээр нь харвал сонирхолтой үр дүн ажиглагдаж байна. Жишээ нь, 60-аас доош насны үелрэлийн хувьд нэг өрхөд ногдох хүний тоо 60-аас дээш насны үелрэлийнхтэй харьцуулахад их байна. Энэ нь 60-аас доош насны үелрэлийнхний хувьд хүүхдүүд нь хараахан тусдаа гарч амжаагүй, эцэг эхийн гэрт хамт амьдарч байгаатай холбон тайлбарлаж болох юм.

**Зураг 3.1.1 Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн хувийн жин, өрхийн бүтэц**



Улаанбаатар хотын гэр бүлийн амьдралын мөчлөгийн судалгааны гол зорилго нь хотын өрх, гэр бүлийн бүтцийг тодорхойлох явдалтай зайлшигүй холбогдож байгаа юм. Тиймээс судалгаанд хамрагдсан нийт эмэгтэйчүүдийн амьдарч буй

өрхийн бүтцийг тодорхойлсон (зураг 1).

Нийт өрхийн талаас илүү хувь нь ам бүлээрээ буюу нуклеар өрх байгаа нь 2000 оны тооллогын Улаанбаатарын үр дүн (52 хувь)-гээс 1,6 пунктээр өндөр гарчээ. Харин нийлмэл өрхийн хувь тус тооллогын үр дүн (39 хувь)-гээс 6,2 пунктээр өссөн байхад холимог өрхийн хувь (4 хувь)-д 2,8 пунктээр буурсан байна. Өрхүүд нийгэмд нийлмэл байдлаар амьдрах хэлбэр ийнхүү өсч байгаа нь олон олон хүчин зүйлээс хамаарч байгаа болов уу. Тухайлбал: хүн амын амьжиргааны түвшин доогуур байдлаас болоод орон сууц худалдан авах чадвар тааруу байгаа, цалингийн түвшин хангалтгүй, ажил эрхлэлт бага зэргийг дурьдаж болох юм. Гэвч нийт өрхийн дийлэнхийг нуклеар өрх эзэлж байгаагаас үндэслэн Улаанбаатар хотын гэр бүлийн амьдралын мөчлөгийг *Glick*-ийн загвараар, өөрөөр хэлбэл гэр бүлийн амьдралын мөчлөг нь биологийн гэр бүлийн хүрээнд явагдах загвараар тодорхойлогдоно гэж үзэж болох юм.

Ерөнхийдөө үсрэлийн нас ахих тусам нуклеар өрхийн тухайн насын үсрэлд эзлэх хувийн жин буурах, эсрэгээр нас залуужих тусам нэмэгдэж байгаа нь хөгшин үсрэлийнхэн хүү/охиныхоо гэрт хамт амьдарч, нийлмэл өрх үүсгэж байгаагаар тайлбарлагдах болов уу.

#### A. Улаанбаатар хотын гэр бүлийн амьдралын мөчлөгийг тодорхойлох нь

Судалгаанд хамрагдсан нийт эмэгтэйчүүдийн гэр бүлийн амьдралын мөчлөгийг тодорхойлоходоо хэд хэдэн загвар болон үсрэл байдлаар гаргахыг хичээлээ. Ерөнхийдөө *Glick*-ийн загварыг гол болгосон. Загвар I-д нөхөр нь нас барах үеийн эмэгтэйн насыг тодорхойлоходоо шууд судалгааны асуулгаас нэгтгэж тооцсон бол загвар II-т 2000 оны Улаанбаатар хотын насжилтийн хүснэгтийн тухайн наснаас цаашид үргэлжлэн амьдрах хүн жилийн тоог ашиглан тооцсон. Мөн бүх загварт эмэгтэйн өөрөө нас барах үеийг тодорхойлоходоо тооллогын насжилтийн хүснэгтийг ашиглав.

Хүснэгт 3.2-т судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн гэр бүлийн амьдралын мөчлөгийн эхний загварыг үзүүлэв. Энэ загварт гэр бүлийн амьдралын мөчлөгийн IY үе (хүүхдүүд гэрээ орхих буюу асрамжаас гарах үе)-ийг тодорхойлоходоо яг хүүхдүүд нь тусдаа (гэрлэх) гарах үеийн эмэгтэйн насаар авч үзсэн.

IY үеийг 2 янзаар тодорхойлох нь онол, арга зүйн хувьд ялгаагүй юм. Гагцхүү мэдээлэл хангалттай биш үед хүүхдүүд нь тусдаа гарах үеийн эмэгтэйн насыг гэрлэх үеийнх нь насаар орлуулан авч болдогт гол онцлог нь оршиж байгаа юм.

Судалгаанд хамрагдсан нийт эмэгтэйчүүдийн хувьд гэр бүлийн амьдралын мөчлөг үсрэл тус бүрийн хувьд хэрхэн ялгаатай байгааг анзаарна уу (хүснэгт 3.2). Тухайлбал: анхны гэрлэлт болон төрөх үеийн эмэгтэйн нас үсрэлийн нас залуужих тусам срөнхийдөө нэмэгдсэн (анхны гэрлэлтийн үеийн эмэгтэйн нас: 65-69 насанд 19,78, 45-49 насанд 22,08, анхны төрөлтийн үеийн эмэгтэйн нас тус тус 20,48, 23,26) байхад хүүхдүүдээс нь хэн нэг нь анх гэрлэх болон тусдаа гарах үеийн эмэгтэйн наснаас бусад насын хувьд байдал эсрэгээр (сүүлийн хүүхэд нь тусдаа гарах /гэрлэх/ үеийн эмэгтэйн нас: 65-69 насанд 62,0 /59,8/, 45-49 насанд 44,2 /46,0/, нөхөр нь нас барах үеийн эмэгтэйн нас тус тус 54,67, 41,93 гэх мэт...) байна. Харин хүүхдүүдээс нь

хэн нэг нь анх тусдаа гарах (гэрлэх) үсийн эмэгтэйн нас үелрэл тус бүрээр харьцангуй тогтвортой байна гэж хэлж болох юм.

*Хүснэгт 2. Эмэгтэйчүүдийн дундаж нас, үелрэл болон  
гэр бүлийн амьдралын мөчлөгөөр (Загвар I)*

Мөчлөгийн үеүд	Насны бүлэг					
	45-49	50-54	55-59	60-64	65-69	70+
Анхны гэрлэлт	22,08	22,31	21,89	21,12	19,78	21,03
Анхны төрөлт	23,26	23,02	22,52	21,92	20,48	23,86
Сүүлийн төрөлт	30,48	32,61	34,53	37,80	38,39	38,30
Хүүхдүүдээс нь хэн нэг нь анх тусдаа гарах үе (Хүүхдүүдээс нь хэн нэг нь анх гэрлэх үе)	42,37	45,11	45,95	44,12	43,91	44,48
Сүүлийн хүүхэд нь тусдаа гарах үе (Сүүлийн хүүхэд нь гэрлэх үе)	44,20	49,00	51,60	55,00	62,00	59,54
Сүүлийн нөхөр нь нас барах үе	41,93	44,83	47,30	48,30	54,67	58,80
<b>Өөрөө нас барах үе*</b>	<b>75,85</b>	<b>76,69</b>	<b>77,7</b>	<b>78,91</b>	<b>80,43</b>	<b>77,82</b>

\*- Насжилтийн хүснэгтээс энэ үсийг тооцсон учраас бүгд нас барна гэж үзсэн

Хүүхдүүдээс нь хэн нэг нь анх тусдаа гарах үе болон хэн нэг нь анх гэрлэх үе хоёрын зөрүү үелрэл бүрээр харьцангуй тогтвортой байна. Харин сүүлийн хүүхэд нь тусдаа гарах үе болон сүүлийн хүүхэд нь гэрлэх үе хоёрын зөрүү хүүхдүүдээс нь хэн нэг нь анх тусдаа гарах, гэрлэх үе хоёрын зөрүүнээс харьцангуй их байна. Энэ нь гэрлэснийхээ дараа тусдаа гарсан үелрэлийнхний (55-59 болон 65-69) хувьд орон сууц худалдан авах бололцоо тааруу, харин гэрлэхээсээ өмнө тусдаа гарсан үелрэлийнхний хувьд (дээрх хоёроос бусад насны үелрэл) залуучууд боловсрол эзэмших, ажил эрхлэх зорилгоор гэрээ орхисон байж болох зэрэг шалтгаанаар тайлбарлагдах болов уу.

Судалгаанд хамрагдсан нийт эмэгтэйчүүдийн хувьд анхны гэрлэлтийн нас нийт байдлаар 21,66, анхны төрөлтийн нас 22,75, сүүлийн хүүхэд төрөх нас 34,12, хүүхдүүдээс нь хэн нэг нь анх тусдаа гарах (гэрлэх) үсийн нас 44,15 (44.80), сүүлийн хүүхэд нь тусдаа гарах (гэрлэх) нас 55,19 (57,48), нөхөр нас барах үсийн нас 49,79 байна.

Судалгааны үр дүнгээс гарсан энэ загвар нь одоогийн хөгжиж байгаа болон хөгжингүй орнуудын 60-100 гаруй жилийн өмнө туулж өнгөрүүлсэн загварын чиг хандлагатай ойролцоо гарчээ (хүснэгт 3.3). Өөрөөр хэлбэл эдгээр орнуудын туулж өнгөрүүлсэн мөчлөгөөс үзэхэд хамгийн сүүлийн хүүхэд нь тусдаа гарах үеэс өмнө нөхөр нь нас барах хандлагатай байсан байна.


**Хүснэгт 3. Эмэгтэйчүүдийн дундаж нас, үсрэл болон сонгосон орнуудаар, 1860-1956**

Мөчлөгийн үеүд	Энэтхэг (Бенарас)	Япон	АНУ	Австрали
		1956	1940	1890
Анхны гэрлэлт	14,6	20,8	22,0	24
Анхны төрөлт	18,2	23,2	23,0	26
Сүүлийн төрөлт	37,0	35,5	31,9	40
Хүүхдүүдээс хэн нэг нь анх тусдаа гарах үс	34,2	-	47,0	52
Сүүлийн хүүхэд нь тусдаа гарах үс	53,0	58,3	55,3	66
Нөхөр нь нас барах үс	39,5	42,9	53,3	56
Өөрөө нас барах үс	54,5	49,6	67,7	76

Эх үүсвэр: "Beginning population studies". Second edition, The Australian National University, 1994

Энэ нь тус судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн амьдралын мөчлөг нь өнөөгийн хөгжиж байгаа болон хөгжингүй орнуудын туулж өнгөрүүлсэн загвартай нийцэж байгааг нотлож байгаа бөгөөд дэлхийн улс орнуудын гэр бүлийн амьдралын мөчлөгийн зүй тогтлоос хазайгаагүйг илтгэж байна.

**Зураг 3.2.1 Судалгаанд хамрагдагсны амьдралын м?чл?г, м?чл?г б?рийн үргэлжлэх хугацаа, үерэлзээр, загвар I**



Зураг 2.-д судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн гэр бүлийн амьдралын мөчлөгийг харуулав. Графикаас харахад гэр бүлийн амьдралын мөчлөгийн I үеийн үргэлжлэх хугацаа нийт эмэгтэйчүүдийн хувьд (үсрэл тус бүрээр хэрхэн ялгаатай байгааг анзаарна уу) 1,09 жил, II үе 11,37 жил, III үе 10,03 жил, IV үе 11,04 жил, V болон VI үе нийтдээ (нөхөр нь хамгийн сүүлийн хүүхэд нь тусдаа гарахаас өмнө нас барж байгаа учраас хосууд эргээд хоёулаа үлдэх үе байхгүй байна) 24,34 жил байна. Үе тус бүрийн үргэлжлэх хугацаа тухайлбал: I, III, VI үе насны бүлэг залуужих тусам нэмэгдэх хандлагатай байхад II болон IV үеийн хувьд буурах хандлагатай байна.

Загвар I-ээс үзэхэд хосууд эргээд хоёул үлдэх үе байхгүй гэсэн үр дүнд хүрч байна. Энэ нь хэдийгээр нэг талаасаа, бусад улс орнуудын үр дүнтэй хандлагын хувьд ижил байгаа боловч нөгөө талаасаа, нөхөр нь нас барсан эмэгтэйчүүдийн нийт эмэгтэйчүүдэд эзлэх хувийн жин бага байсантай холбоотойгоор нөхөр нь нас барах үсийн эмэгтэйн нас сүүлийн хүүхэд нь тусдаа гарах үсийн наснаас бага гарсан байж болох талтай юм. Тиймээс загвар II-т нөхөр нь нас барах үсийг 2000 оны тооллогын үр дүнгээс тооцсон Улаанбаатар хотын насжилтийн хүснэгтийн тухайн наснаас цааш үргэлжлэн амьдрах хүн жилээр төлөөлүүлэн бодож гаргав (хүснэгт 3.4).

*Хүснэгт 4. Эмэгтэйчүүдийн дундаж нас, үелрэл болон  
гэр бүлийн амьдралын мөчлөгөөр (Загвар II)*


Мөчлөгийн үеүд	Насны бүлэг					
	45-49	50-54	55-59	60-64	65-69	70+
Анхны гэрлэлт	22,08	22,31	21,89	21,12	19,78	21,03
Анхны төрөлт	23,26	23,02	22,52	21,92	20,48	23,86
Сүүлийн төрөлт	30,48	32,61	34,53	37,80	38,39	38,30
Хүүхдүүдээс хэн нэг нь анх тусдаа гарах үе	42,37	45,11	45,95	44,12	43,91	44,48
Сүүлийн хүүхэд нь тусдаа гарах үе	44,20	49,00	51,60	55,00	62,00	59,54
Нөхөр нь нас барах үе*	72,15	73,36	74,81	76,51	78,55	76,77
Өөрөө нас барах үе**	75,85	76,69	77,70	78,91	80,43	77,82

\*- Насжилтийн хүснэгтээс тооцсон насаар

\*\*- Насжилтийн хүснэгтээс энэ үсийг тооцсон учраас бүгд нас барна гэж үзсэн

#### Судалгаанд хамрагдсан

эмэгтэйчүүдийн гэр бүлийн амьдралын мөчлөгийн эхний 4 үсийн үргэлжлэх хугацаа өмнөх 2 загварын үргэлжлэх хугацаатай адил байна. Хосууд эргээд хоёулаа үлдэх үе нийт байдлаар судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 52-71 насанд, бэлэвсэн үе цаашид 2 жил гаруй үргэлжиж, гэр бүлийн нэгэн үсийн амьдрал дуусч



байна (зураг 3.2.2). Амьдралын мөчлөгийн сүүлийн 2 үсийн үргэлжлэх хугацаа үелрэлийн нас (насны бүлэг) залуужих тусам нэмэгдэх хандлагатай байна. Энэхүү загварын өмнөх загвараас ялгарах гол онцлог тал нь одоогийн хөгжингүй орны туулж өнгөрүүлсэн чиг, хандлагыг тусгасан байдал юм (хүснэгт 5).

*Хүснэгт 5. Эмэгтэйчүүдийн дундаж нас, үелрэл болон сонгосон орнуудаар, 1950-1972*

Мөчлөгийн үеүд	Белги	Япон	АНУ	Австрали
	1968	1972	1950	1940
Анхны гэрлэлт	22	23,1	20,1	21
Анхны төрөлт	23	25,3	21,8	23
Сүүлийн төрөлт	28	27,9	26,1	29
Хүүхдүүдээс хэн нэг нь анх тусдаа гарах үе	46	-	43,3	45
Сүүлийн хүүхэд нь тусдаа гарах үе	51	52,5	47,6	52
Нөхөр нь нас барах үе	66	67,1	61,4	67
Өөрөө нас барах үе	80	75,5	77,2	83

Хамгийн сүүлийн хүүхэд нь тусдаа гарах үсийн эмэгтэйн нас нь нөхөр нь нас барах үсийн нааснаас бага буюу хосууд эргээд хоёулаа үлдэх үсийг тодорхойлж болдог нь улс орнуудын хөгжлийн түвшин өндөрсөхийн хирээр дундаж наслалт нэмэгддэгтэй холбоотой.

Хэдийгээр Улаанбаатар хотод нуклеар өрх нийт өрхийн дийлэнх хувийг бүрдүүлж байгаа боловч мөн нийт өрхөд багагүй хувийг эзэлсээр байгаа нийлмэл өрхийн бүтцийг огт хайхралгүй орхиж болохгүй юм. Өөрөөр хэлбэл Glick-ийн ангиллаар судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн гэр бүлийн амьдралын мөчлөгийг тодорхойлох нь бүрэн үндэслэлтэй боловч нийлмэл өрхийн бүтцээр тодорхойлогдох гэр бүлийн амьдралын мөчлөгийн загварыг авч үзэх нь ач холбогдолтой юм. Энэ үндсэн дээр Монголын судлаачдын дэвшүүлсэн санаанд түшиглэн дараагийн загварыг гаргая. Ингэхдээ Т.Намжил, П.Үвш, Д.Тунгалаг нарын дэвшүүлсэн загварыг үндэс болгох нь зүйтэй гэж үзлээ (зураг 3.2.3). Учир нь энэ загвар нь Монголын нөхцөлд тохирсон, сүүлийн үед ихээхэн хэмжээгээр бий болоод байгаа нийлмэл өрхийн хэв шинжийг хамгийн их агуулж чадна гэж бодож байна. Т.Намжил нар энэхүү санааг дэвшүүлэхдээ үе тус бүрийг яг ямар аргаар тодорхойлох эсэхийг авч үзээгүй. Иймээс өөрөө дараах онцлог байдлыг агуулсан насаар тэд нарын дэвшүүлсэн үеүдийг тодорхойлж болох юм гэж үзлээ (хүснэгт 6).

*Хүснэгт 6. Эмэгтэйчүүдийн дундаж нас, үелрэл болон гэр бүлийн амьдралын мөчлөгөөр (Загвар III)*


Мөчлөгийн үеүд	Насны бүлэг					
	45-49	50-54	55-59	60-64	65-69	70+
Анхны гэрлэлт	22,08	22,31	21,89	21,12	19,78	21,03
Анхны төрөлт	23,26	23,02	22,52	21,92	20,48	23,86
Хүүхдүүдээс нь хэн нэг нь анх тусдаа гарах үе	42,37	45,11	45,95	44,12	43,91	44,48
Сүүлийн хүүхэд нь гэрлэх үе	46,00	49,25	51,33	56,40	59,80	62,22
Эцэг эх тэтгэвэрт гарах үе	60,0	60,0	60,0	60,0	60,0	60,0
Өөрөө нас барах үе*	75,85	76,69	77,7	78,91	80,43	77,82

\*- Насжилтийн хүснэгтээс энэ үсийг тооцсон учраас бүгд нас барна гэж үзсэн

Хүснэгт 6-аас харахад эхний хоёр болон хамгийн сүүлийн үсийн нас нь өмнөх загваруултай адил байх юм. Харин сүүлийн төрөлтийн насыг тусад нь салгаж авч үзээгүй бөгөөд хүүхдүүдээс нь хэн нэг нь анх тусдаа гарах үсийг шууд тодорхойлсон.

Тухайн үеийг тодорхойлох насан дээр нэг анхаарах ёстой зүйл нь хамгийн сүүлд тусдаа гарах үеийг хамгийн сүүлд гэрлэх үеэр авах явдал юм. Энэ нь нийлмэл гэр бүлийн онцлогийг тусгах зорилготой юм. Өөрөөр хэлбэл хамгийн сүүлийн хүүхэд нь гэрлэсэн эсвэл гэрлээгүй ч бай заавал тусдаа гарах албагүй бөгөөд ядаж нэг хүүхэд (хамгийн сүүлийн хүүхдээр нь төлөөлүүлэн авч үзвэл) нь эцэг эхтэйгээ хамт амьдрах нөхцөл болж өгч байна. Хүүхэд эцэг эх хамт ажиллах үеийг тодорхойлохдоо Монгол улсын хэмжээнд мөрдөгдөж буй тэтгэврийн насыг ашигласан.

Т.Намжил нарын загвараар судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн гэр бүлийн амьдралын мөчлөгийг тодорхойлбол эхний 2 үе нь өмнөх загваруудын үр дүнтэй ижил гарсан байна (зураг 3.2.3). Харин үр хүүхдээ асран хүмүүжүүлэх үе нь нийт эмэгтэйчүүдийн хувьд (үелрэл тус бүрээр хэрхэн ялгаатай байгааг зураг 3.2.3-аас харна уу) 21,07 жил, үр хүүхэд асрамжаас гарч бие даах үе 11,04 жил, хүүхэд эцэг эх мөр зэргэцэн ажиллах үе 7,41 жил, гэр бүлийн амьдралын намар үе 17,9 жил тус үргэлжилж байна.



Гэр бүлийн амьдралын мөчлөгийн үелрэл тус бүрийн хувьд эхний болон IY үеийн үргэлжлэх хугацаа цаашид нэмэгдэх, III үе буурах хандлагатай байгаа бол бусад үеүд нь харьцангуй тогтвортой байна.

Эцэст нь дээрх 3 загварын аль аль нь судалгаа шинжилгээний хувьд ихээхэн ач холбогдолтой юм.

Тухайлбал: эхний загвар

нь нуклеар гэр бүл зонхилсон нийгэмд тохирох бол дараагийнх нь одоогийн өндөө хөгжилтэй орнуудад илүү ойтож очиж байна. Харин сүүлийн III дахь загвар нь нийлмэл өрх нийгэмд зонхилсон үед илүүтэйгээр ашиглагдана гэж бодож байна.

Тиймээс судалгааны үр дүнгээс тодорхойлсон дээрх загваруудаас I загвар нь Улаанбаатар хотын гэр бүлийн амьдралын мөчлөгийн шинж байдлыг илүү тусгаж чадна гэж үзэж байна. Учир нь нэгдүгээрт, Улаанбаатар хотод нуклеар гэр бүл зонхилсон байна. Хоёрдугаарт, тус загвар нь өнөөгийн хөгжиж буй болон хөгжингүй орнуудын туулж өнгөрүүлсэн түүхэн зүй тогтолтой тохирч байна.

#### Б. Гэр бүлийн амьдралын мөчлөгт гарч буй өөрчлөлтийг тайлбарлах нь

Гэр бүлийн амьдралын мөчлөгийг үелрэл байдлаар судлах нь нийгэм, эдийн засаг, хүн ам зүйн түүхэн үйл явцыг судалх асуудалтай шууд холбогдож байдаг. Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн гэр бүлийн амьдралын мөчлөгийн *öжöйääжé* (загвар I)

тухайн эмэгтэйн 20-22 орчим насанд эхэлж байна. Үелрэлийн нас залуужих тусам анхны гэрлэлтийн нас хойшилсон болон эхний үсийн үргэлжлэх хугацаа нэмэгдсэн байгааг зураг 3.2.1-ээс харж болно.

70-аас доош насны үелрэлийн хувьд анхны гэрлэлтийн болон анхны төрөлтийн нас аажим өссөн байна. Энэ нь анхны гэрлэлтийн нас улс орны хөгжлийн явцад олон жилийн туршид бага багаар нэмэгддэг хандлагыг тусгаж байна. Харин 70-аас дээш насны үелрэлийн анхны гэрлэлтийн нас харьцангуй өндөр байгаа нь 1935-аас өмнөх үсийн нийгэм, эдийн засаг, хүн ам зүйн түүхэн байдалтай холбоотой байх.

Тухайлбал: 1918 оны тоологоор хүн амын өсөлт сөрөг гарсан бөгөөд 1950-иад оныг хүргэл дорвитой өсч чадаагүй нь нэг талаараа гэрлэлтгэй нягт холбоотой. Учир нь дээрх онуудад жил бүр дунджаар 80 мянга орчим эрсийг цэргийн албанц татаж байсан бол насанд хүрсэн нийт эрчүүдийн 40 орчим хувь нь сүм хийдэд эхнэр авалгүй шавилан сууж байв. Түүнчлэн тухайн үсийн гэрлэх насны нийт эмэгтэйчүүдийн 30-40 хувь нь гэр бүлгүй байжээ (*MХАХН, ХАССТ: “Монголын хүн амын сэтгүүл”*. дугаар 7. 2002: 72-р тал). Мөн 1932 оны “Шинэ өөрчлөлтийн бодлого”-ын нөлөөгөөр дэгдсэн бослого, 1937 оны “хэлмэгдүүлэлт”-ийн хар мөртэй зайлшигүй холбоотой байна. Түүнчлэн XX зууны эхэн үсийн нийгмийн халдварт өвчин их, тархалт газар авсанаас нас барагтын түвшин өндөр байсантай холбоотой байж болох талтай. Энэ бүх нөхцөл байдлын улмаас анхны гэрлэлтийн болон төрөлтийн нас оройтох байсан байж болзошгүй.

Харин 70-аас доош насны үелрэлийн хувьд арай өөр тайлбарыг өгч болохоор байна. Дэлхийн II дайны дараагаас эхлэн хүн амаа өстөх эрчимтэй бодлогын үр дүнд хүн амын дунд гэрлэлт болон төрөлтийн түвшин нэмэгдэж, насны хувьд залуужсан (65-69 насны үелрэлийн хувьд анхны гэрлэлтийн нас 19,78, анхны төрөлтийн нас 20,48 байна /загвар I/). Тус бодлогын хүрээнд хүн амын дунд эрүүлийг хамгаалах үйлчилгээг түгээн дэлгэрүүлж, бүх нийтийг боловсролтой болгох соёлын довтолгоон өрнүүлсэн (нэгдүгээр үе болон боловсролын түвшин хоёрын хооронд судалгааны асуулгын хүрээнд хүчин зүйлийн шинжилгээ хийхэд ээрэг хамаарал /нийлэмжтэй хамааралтай, корреляцийн коэффициент 0,169\*\*, ач холбогдлын түвшин 0,003 ба \*\* байгаа нь эх олонлогт тархаах магадлал 95 хувь/ байсан), нийгмийн хамгааллын тогтолцоог боловсронгуй болгосон болон хүн амын амьжирагааны чадавхийг нэмэгдүүлсэн зэрэг олон олон үйл ажиллагааны үр дүнд нийгэм, эдийн засаг, улс орны байдал сэргэж ирсэн. Ийнхүү улс орны хөгжлийн түвшин нэмэгдэхийн хирээр анхны гэрлэлт болон төрөлтийн нас хойшилсон байна (45-49 насны үелрэлийн хувьд анхны гэрлэлт болон төрөлтийн нас харгалзан 22,08, 23,26 байна). Ялангуяа анхны төрөлтийн нас гэрлэлтийн наснаас илүү хурдтайгаар оройтох болсон нь хүүхэдгүй үсийн үргэлжлэх хугацаа нэмэгдэхэд нөлөөлж байна.

*Хүүхэд төрүүлэх үсийн үргэлжлэх хугацаа 65-69 наснаас дооших үелрэлийнхний хувьд насны бүлэг залуужихын хирээр багассан байна. 70-аас дээш насны үелрэлийн хувьд өмнөх 60-69 насны үелрэлийнхнээс байгаа байгаа нь XX зууны эхний хагаст төрөлтийн түвшин бага байсныг харуулж байна. Энэ үесэс төрөлтийг дэмжих бодлогыг тууштай авч хэрэгжүүлсэн нь хүүхэд төрүүлэх үед нөлөөлснийг 65-69 насны үелрэлийнхний хувьд энэ үсийн үргэлжлэх хугацаа нэмэгдсэнээр тайлбарлах нь зүйтэй. Харин 1970-аад оны сүүлээс төрөлтийн түвшин буурсан нь 65-69 насанд*

хүүхэд төрүүлэх үсийн урт 18 орчим жил байснаа 45-49 насанд 7 жил болтлоо буурсан явдлаар батлагдаж байна.

Хүүхэд төрүүлэх үед хүн ам зүйн болон нийгэм эдийн засгийн хүчин зүйлс нөлөөлдөг нь онолын хувьд батлагдсан билээ. Үүнийг шалгах зорилгоор төрөлт хоорондын зайд, нийт төрүүлсэн хүүхдийн тоо (хүн ам зүйн хүчин зүйлс) болон тухайн эмэгтэйн боловсрол, орлого (нийгэм, эдийн засгийн хүчин зүйлс) хоёр хэрхэн нөлөөлөхийг авч үзсэн.

Ингэхэд орлогоос бусад хүчин зүйлсийн хувьд ач холбогдлын түвшин өндөр гарсан. Нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсээс сонгосон 2 хувьсагчийн хувьд орлого болон II үсийн хооронд хамаарал байхгүй, харин эмэгтэйн боловсролын түвшин хүүхэд төрүүлэх үе хоёрын хооронд сөрөг хамааралтай буюу боловсролын түвшин нэмэгдэхийн хирээр II үсийг бага хугацаа (1-6 жил)-нд тулан өнгөрүүлж буй эмэгтэйчүүдийн хувь (50 хувь) ихсэж байсан.

Харин II үсийн хүн ам зүйн хүчин зүйлсээс хамаарах хамаарал эерэг байв. Өөрөөр хэлбэл нийт төрүүлсэн хүүхдийн тоо болон төрөлт хоорондын зайд нэмэгдэхийн хирээр хүүхэд төрүүлэх үсийн үргэлжлэх хугацаа нэмэгдэж байлаа. Дээрх хоёр хувьсагчийн ач холбогдлын түвшин өндөр (0,000) байгаа нь II үсийг тэдгээр нь тайлбарлаж чадахыг харуулж байгаа юм. Харин чухам аль хүчин зүйл нь илүү тайлбарлаж чадахыг хоёулангийнх нь хувьд корреляцийн коэффициент тооцсоноор гаргаж ирэв. Ингэхдээ хувьсагчдыг нэг нэгээр нь бие биенээс нь хамаарахгүй байхаар эсвэл аль нэгийг нь нөгөөхийнх нь хяналтын хувьсагчаар сонгон тооцоход нийт төрүүлсэн хүүхэд болон II үсийн үргэлжлэх хугацаа хоёрын хоорондох хамаарал (дангаараа хамаарах байдал 0,657\*\*, төрөлт хоорондын зайд хяналтын хувьсагчаар нь сонгоход 0,913 гарсан) төрөлт хоорондын зайд болон II үс хоёрын хоорондох хамаарал (тус тус 0,507\*\*, 0,883 гарсан)-аас илүү хүчтэй байв. Тиймээс хүүхэд төрүүлэх үсийг төрөлт хоорондын зайнас илүүтэйгээр нийт төрүүлсэн хүүхдийн тоо нь тайлбарлаж чадна гэж дүгнэж болох юм.

Хүүхдүүдээ өсгөх үе нь ямар нэгэн гадны хүчин зүйлсээс хамгийн хамаарал багатай байдаг. Учир нь байгалийн жам ёсны дагуу явагдах хүүхдүүдийнх нь нэгээс нөгөө насанд шилжих үйл явцаар тодорхойлогддог. Өөрөөр хэлбэл хосуудын анхны төрүүлсэн хүүхэд нь энэүед өсөж хүмүүжсээр байдаг бөгөөд анхны хүүхэд нь тусдаа гарснаар дуусгавар болдог.

Ерөнхийдөө хүүхэд төрүүлэх болон хүүхдүүдээ өсгөх үсийн үргэлжлэх хугацаа нь тухайн нийгэмд тогтсон хүүхдүүдээс нь хэн нэг нь анх тусдаа гарах (анхны гэрлэлтийн) үсийн настай тэнцүү байдаг байна. Хүүхдүүдээ өсгөх үсийг судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн үелрэлээр харвал насны бүлэг залуужих тусам нэмэгдэж байна. Өөрөөр хэлбэл 70-аас дээш насны үелрэлийн хувьд хүүхдүүдээ өсгөх үсийн үргэлжлэх хугацаа 6 жил гаруй байхад 45-49 насны үелрэлийн хувьд 12 орчим жил байна. Энэ нь залуу үелрэлийн хувьд эрт хүүхэд төрүүлэх үе нь дууссан учир хүүхдүүдээ өсгөх үе нь урт байгаагаар тайлбарлагдана. Харин хөгшин үелрэлийн хувьд энэ үсийн үргэлжлэх урт богино байгаа нь төрөлтийн түвшин өндөр байсантай холбоотой.

Хүүхдүүд гэрээ орхих буюу асрамжаас гарах үе нь гэр бүлийн амьдралын мөчлөгийн нилээн анхаарал татсан хэсэг болдог. Энэ үед нийгэм, эдийн засгийн болон хүн ам зүйн хэд хэдэн хүчин зүйлс нөлөөлдөг. Тухайлбал: нэгдүгээрт хүүхэд төрүүлэх үсийн үргэлжлэх хугацааны урт, хүүхдүүдийнх нь анхны гэрлэлт болон тусдаа гарах үсийн нас, хүүхдүүдийн хүйс, гэрээ орхиж явах болсон шалтгаан, орлого, хүүхдүүдийн боловсрол зэрэг хүчин зүйлс багтдаг.

Зураг 3.2.1-ээс хараад 70-аас дээш насын үелрэлээс огцом өсөөд, залуу насын үелрэлүүдэд тогтвортой буурсан байна. 65-69 насын үелрэлийн хувьд хүүхдүүд гэрээ орхих үе нь хамгийн урт буюу 18 жил байхад 45-49 насын үелрэлийнхний хувьд 2 орчим жил байна. Ийнхүү IY үсийн үргэлжлэх урт богиносох болсон нь төрөлтийн түвшний бууралттай холбоотой юм. Учир нь судалгаанд хамрагдсан залуу насын эмэгтэйчүүдийн хүүхэд төрүүлэх үе нь эрт дууссан тул хүүхдүүд нь эрт гэрээ орхиж байна.

Дээрх дөрвөн хүчин зүйлсээр хамаарлын шинжилгээ хийж аль хувьсагч нь IY үед илүү нөлөөлж байгааг авч үзэхэд хүүхэд төрүүлэх үсийн урт болон анх тусдаа гарсан хүүхдийнх нь боловсролтой өндөр хамааралтай гарсан. IY болон II үсийн хоорондох хамаарал зэрэг, хамаарлын хүч нь 0,757\*\*, ач холбогдлын түвшин 0,000 гарсан. Энэ нь хүүхэд төрүүлэх үсийн үргэлжлэх хугацаа хэдий урт байна төдий чинээ IY үе нь удаан үргэлжлэхийг харуулж байна. Харин бусад хүчин зүйлсийн хувьд хамаарал нь ач холбогдлын түвшний хувьд хангалтгүй байсан. Онолын хувьд дээр дурьдсан хүчин зүйлс нь IY үед нөлөөлөхийг баталдаг боловч тухайн тохиолдолд биесэнгүй.

*Нөхөр нь нас барах үеийг үелрэл тус бүрээр харвал нилээн ялгаатай байна. Тухайлбал: 70-аас дээш насын үелрэлийн хувьд нөхөр нь нас барах үе хамгийн сүүлийн хүүхэд тусдаа гарах үеэс 0,74 жилийн өмнө, 65-69 насын үелрэлд 7,33 жил, 60-64 насанд 6,7 жил, 55-59 насанд 4,3 жил, 50-54 насанд 4,17 жил, 45-49 насын хувьд 2,27 жилийн өмнө байна. Энэ нь хэдийгээр дэлхийн бусад орнуудын туулж өнгөрүүлсэн хандлагыг илэрхийлж байгаа боловч анхаарал зайлшигүй хандуулах асуудал байна. Учир нь сүүлийн үед нийгэмд гэмт хэрэг өссөн, эрэгтэйчүүдийн амьдралын буруу зан үйл болох архи, тамхи хэтрүүлэн хэрэглэх явдалтай холбоотой байж болох талтай.*

Нөхөр нь нас барах үе сүүлийн хүүхэд нь тусдаа гарах үеэс өмнө тохиолдож байгаа учраас бэлэвсэн үсийн үргэлжлэх хугацаа бусад үеүдийн үргэлжлэх хугацаатай харьцуулахад нилээн урт хугацаагаар явагдаж байна. Үелрэл тус бүрийн хувьд залуужих тусам бэлэвсэн үе нэмэгджээ. Эндээс өнгөцхөн харж дүгнэлт хийвэл нийгэм, эдийн засгийн хөгжлийн явцад дундаж наслалт нэмэгдсэнээр бэлэвсэн байх үе урт хугацаагаар үргэлжилж байна гэж болохоор байна. Гэвч энэ нь тухайн судалгааны хувьд дундаж наслалт нэмэгдсэнээр энэ үе уртасч байгаа хэрэг бус харин залуу насын үелрэлүүдийн хувьд төрөлтийн түвшин буурснаас III, IY үеүд эрт явагдаж дууссантай холбоотой юм. Тиймээс 45-49 насын үелрэлийн хувьд бэлэвсэн үе тухайн насын эмэгтэйчүүдийн 42-76 насын хооронд 70-аас дээш насын үелрэлийнхний хувьд 59-78 насанд тохиолдохоор байна (эмэгтэйчүүдийн өөрөө нас барах үеийг насжилтийн хүснэгтээс орлуулан авч тооцсон учраас дээрх тохиолдолд магадлалт байдлаар тайлбарлах нь зүйтэй-хүснэгт 4.2.2-ыг эргэн харна уу).

Бэлэвсэн үеийн урт байх хугацаа нь өрөнхийдөө дундаж наслалтаас хамаарах бөгөөд мөн тухайн эмэгтэйн эрүүл мэндийн байдал, амьжиргааны түвшин болон нийгмийн халамж, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж болон эмэгтэйн сэтгэл санааны байдал зэрэг олон хүчин зүйлээс хамаардаг.

Эцэст нь судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн гэр бүлийн амьдралын мөчлөгийн үе тус бүрт нийгэм, эдийн засаг, хүн ам зүйн олон хүчин зүйлс нөлөөлж байгааг энэ бүлэгт багахан ч болов гаргахыг хичээллээ. Зөвхөн тус судалгааны асуулгын хүрээнд эдгээр хүчин зүйлсийг тодорхойлсон учраас орхигдуулсан зүйл байгаа нь мэдээж юм. Гэвч цааш цаашдын судалгааны ажилд илүү дэлгэрүүлэн, нарийн судлах шаардлагатай юм.

Гэр бүлийн амьдралын мөчлөгийн хүн ам зүй, нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Гэр бүлийн амьдралын мөчлөгийн судалгаа нь нийгэм эдийн засгийн төлөвлөлт (тухайлбал: орон сууцны төлөвлөлт гэх мэт) зэрэгт чухал ач холбогдолтой. Гэр бүлийн амьдралын мөчлөг нь гэрлэлт, төрөлт, нас баралт болон шилжих хөдөлгөөнийг тусгаж байдаг бөгөөд түүний үеүд нь нийгэм, эдийн засаг, хүн ам зүйд ямар ямар үр нөлөөг бий болгох талаар авч үзье.

Тухайлбал: хосууд гэрлэсэн/хамт амьдарч эхэлснээс анхны хүүхдээ төрүүлэх хүртэл хугацаа (хүүхэдгүй үе) урт байх нь эдийн засаг талаасаа хосуудад ажил эрхлэлт нэмэгдэх, орлого олох, хуримтлал хийх, боловсролоо дээшлүүлэх бололцоо олгодог. Мөн залууст зориулсан үйлчилгээний эрэлт өсөх гэх мэт эдийн засгийн хувьд ашигтай байдлыг бий болгодог. Өөрөөр хэлбэл энэ үед л хосууд цаашдын ажил, амьдрал, орлогын эх сууриа бат тавьдаг байна. Энэ үед эмэгтэйчүүдийн хөдөлмөр оролцооны түвшин харьцангуй өндөр байдаг нь тэдний нийгэмд эзлэх байр суурийг нэмэгдүүлэхэд сайнаар нөлөөлөх талтай. Харин хүн ам зүйн үүднээсээ хүүхэдгүй үеийн үргэлжлэх хугацаа уртсах нь төрөлтийн түвшин буурах нөхцлийг бүрдүүлдэг. Тиймээс энэ талаасаа нийгэмд, ялангуяа хүн амаа өсгөх бодлого баримталж буй улс орнуудад хохирол учруулдаг.

Хосууд анхныхаа хүүхдийг төрүүлэх нь тэдний амьдралыг бүхэлд нь өөрчилдөг. Энэ үед тэдний ялангуяа эмэгтэйчүүдийн чөлөөт цаг багасч, өөрийн сайн сайхны төлөө зориулах байсан цаг хүүхдээ асрах хүмүүжүүлэх байдалд шилждэг. Хүүхэд төрүүлэх үеийн үргэлжлэх хугацаа урт байх нь хүн ам зүйд хоёр үр дагаврыг бий болгох талтай. Өөрөөр хэлбэл энэ үеийн үргэлжлэх хугацаа урт байх нь төрөлтийн түвшин өндөр байгаа улс орнуудад төрөлт нэмэгдэх хандлагыг бий болгодог бол төрөлтийн түвшин доогуур орнуудад төрөлт хоорондын зайд нэмэгдэхэд хүргэдэг. Хүүхэд төрүүлэх үе урт байх нь гэр бүл болон улс оронд ч ачааллыг нэмэгдүүлдэг. Гэр бүлийн хүрээнд илүү их орлого олох шаардлага тулгардаг бол улс орнуудад хүүхдийн тэтгэмжийн зардал нэмэгдэх байдал бий болдог байна. Ийнхүү хүүхдийн өртөг өндөрсөх нь хосууд хүүхдийн хэрэгцээг бодолцож үзэхэд хүргэнэ.

Хүүхдээ өсгөх үе нь эцэг эхээс илүү их анхаарал, хөрөнгө мөнгө шаардаж байдаг. Хүүхдээ төрүүлэх үсэс ч илүү их хөрөнгө мөнгийг шаардах бөгөөд хүүхдийнхээ өмнө хүлээх хариуцлагыг ч нэмэгдүүлдэг. Хэрвээ хүүхэд төрүүлэх үе нь харьцангуй урт

хугацаанд үргэлжилсэн бол энэ үед нийгэмд боловсролын үйлчилгээний эрэлт зэрэг хүүхдээ өсгөж хүмүүжүүлэхтэй холбоотой олон зардлууд нэмэгддэг байна. Ихэнх хөгжингүй орнуудад хүүхдээ өсгөх үеэс эхоэн эмэгтэйчүүдийн хөдөлмөр оролцооны хувь дээшилдэг. Хүүхэдгүй болон хүүхдээ өсгөх үед хүүхдээ төрүүлэх үетэй харьцуулахад хосууд өөрсдийнхөө болон үр хүүхдийнхээ сайн сайхны төлөө шилжих хөдөлгөөнд орох магадлал өндөр байдаг.

Хүүхдүүд гэрээ орхих буюу асрамжаас гарах үед хосууд сая л амсхийдэг байна. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр оролцоо нэмэгдэснээр дахин орлогоо нэмэгдүүлэх, хуримтлал хийх боломжтой болно. Энэ үеийн үргэлжлэх хугацаа урт байх нь эдийн засагт орон сууцны хэрэгцээг, хөдөлмөрийн зах зээл дээр ажиллах хүчний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх бөгөөд нийгмийн халамжийн зардал хамгийн бага байх нөхцөл бүрддэг. Хүүхдүүд асрамжаас гарах үе нь өрхийн ачаалал буурах таатай нөхцлийг бүрдүүлдэг бөгөөд макро түвшинд хүн ам зүйн ачаалал буурах хандлагатай.

Хосууд эргээд хоёулаа үлдэх үед эцэг эхчүүд хүүхэдгүй байх үетэй адил байдалтай байна.

Бэлэвсэн үе нь нийгэм болон хүн ам зүйд олон олон үр дагаврыг бий болгодог. Тухайлбал: нийгмийн халамжийн зардал, эрүүл мэндийн үйлчилгээ гээд бүхий л түвшинд ачаалал нэмэгддэг.

#### 4. Дүгнэлт

Улаанбаатар хотын гэр бүлийн амьдралын мөчлөгийн судалгаагаар нийт өрхийн дийлэнх хувийг нуклеар ам бүл эзэлж байгаа учраас судалгаанд хамрагдагсдын гэр бүлийн амьдралын мөчлөгийг тодорхойлохдоо биологийн гэр бүлийн хүрээнд явагдах өөрчлөлтийг тусгасан загвар (Glick-ийн загвар) -аар тодорхойлох нь зүйтэй байлаа.

Судалгааны явцад гэр бүлийн амьдралын мөчлөгийг тодорхойлохдоо З загварыг тодорхойлох нь зүйтэй гэж үзсэн. Эхний загвар нь нийгэмд ам бүлээрээ байгаа өрх зонхилж байгаа үед илүү тохирох бол хоёр дахь нь эхний загварын хүрээнд нөхрийнх нь нас барах үеийг насжилтийн хүснэгтээр өргөжүүлэн авч үзсэнээрээ онцлогтой. Гурав дахь загвар нь нийлмэл гэр бүлийн шинжийг илүү гаргахад тохирсон загвар юм.

Нэг дэх загвараар судалгаанд хамрагдсан нийт эмэгтэйчүүдийн хувьд анхны гэрлэлтийн нас нийт байдлаар 21,66, анхны төрөлтийн нас 22,75, сүүлийн хүүхэд төрөх нас 34,12, хүүхдүүдээс нь хэн нэг нь анх тусдаа гарах (гэрлэх) үеийн нас 44,15 (44.80), сүүлийн хүүхэд нь тусдаа гарах (гэрлэх) нас 55,19 (57,48), нөхөр нас барах үеийн нас 49,79 байна.

Гэр бүлийн амьдралын мөчлөгийн I үеийн үргэлжлэх хугацаа нийт эмэгтэйчүүдийн хувьд 1,09 жил, II үе 11,37 жил, III үе 10,03 жил, IV үе 11,04 жил, V болон VI үе нийтдээ 24,34 жил байна.

Хоёрдугаар загвараар тооцож үзэхэд хосууд эргээд хоёулаа үлдэх үе 19 жил үргэлжилж, бэлэвсэн үе 2 орчим жил үргэлжилж байна.

Ерөнхийдөө дээрх хоёр загвар нь өнөөгийн хөгжиж байгаа болон хөгжингүй орнуудын туулж өнгөрүүлсэн түүхэн хэв маягийг илэрхийлж байв.

Т.Намжил нарын загвараар судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн гэр бүлийн амьдралын мөчлөгийг тодорхойлబол эхний 2 үе нь өмнөх загваруудын үр дүнтэй ижил гарсан байна. Харин үр хүүхдээ асран хүмүүжүүлэх үе нь нийт эмэгтэйчүүдийн хувьд 21,07 жил, үр хүүхэд асрамжаас гарч бие даах үе 11,04 жил, хүүхэд эцэг эх мөр зэргэцэн ажиллах үе 7,41 жил, гэр булийн амьдралын намар үе 17,9 жил тус тус үргэлжилж байна.

Нэгдүгээр үе нь анхны гэрлэлтийн нас болон анхны төрөлтийн наснаас хамаардаг. Энэ үеийн үргэлжлэх хугацаа нь дээрх хоёр хүчин зүйлсээс хамааралтай байгаа нь Монголын хүн ам зүйн түүхэн өөрчлөлтөөр батлагдаж байна. Харин эхний үед нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдээс боловсролыг сонгон авч хамаарал тооцоход (эерэг) хамааралтай гарсан

Хүүхэд төрүүлэх үед хүн ам зүйн болон нийгэм эдийн засгийн хүчин зүйлс нөлөөлдөг. Нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсээс сонгосон 2 хувьсагчийн хувьд орлого болон II үеийн хооронд хамаарал байхгүй байна. Харин эмэгтэйн боловсролын түвшин хүүхэд төрүүлэх үе хоёрын хооронд сөрөг хамааралтай харин II үеийн хүн ам зүйн хүчин зүйлсээс хамаарах хамаарал эерэг байна.

Хүүхдүүд гэрээ орхих буюу асрамжаас гарах үед нийгэм, эдийн засгийн болон хүн ам зүйн хэд хэдэн хүчин зүйлс нөлөөлдөг. Дээрх дөрвөн хүчин зүйлсээр хамаарлын шинжилгээ хийж үзэхэд хүүхэд төрүүлэх үсийн урт болон анх тусдаа гарсан хүүхдийнх нь боловсролтой өндөр хамааралтай гарсан. IY болон II үеийн хоорондох хамаарал эерэг байна. Энэ нь хүүхэд төрүүлэх үеийн үргэлжлэх хугацаа хэдий урт байна төдий чинээ IY үе нь удаан үргэлжлэхийг харуулж байна. Нөхөр нь нас барах үе сүүлийн хүүхэд нь тусдаа гарах үесэ өмнө тохиолдож байгаа учраас бэлэвсэн үеийн үргэлжлэх хугацаа бусад үеүйдийн үргэлжлэх хугацаатай харьцуулахад нилээн урт хугацаагаар явагдаж байна.

#### Ашигласан материал

- *Beginning population studies*". Second edition, The Australian National University, 1994
- Д.Тунгалаг, "Гэр бүлийн ёс суртахуун", УБ хот, 2000 он.
- МҮ-ын ерөнхийлөгчийн тамгын газар, НХХЯ, УА, "Өнөөгийн Монголын гэр бул: Хөгжлийн чиг хандлага", УБ, 2002 он.
- МХАХН, ХАССТ, НУБХАС, "Монголын хүн амын сэтгүүл", Дугаар 7, 2002 он.
- Д.Ганхуяг, "Монгол өрх ба хүн амын бүтэц, хэв шинж"-Дипломын ажил, МУИС-ЭЗС, УБ, 1997 он.
- Т.Намжил, Д.Тунгалаг, П.Увш, "Монгол гэр бул: Хөгжил, өөрчлөлт, төлөв", Гэр бүл судлалын төв, Улаанбаатар хот, 2004 он.
- □Хүн ам, орон сууцны 2000 оны тооллого. Улаанбаатар хотын тооллогын □р д□н□. □СГ. Улаанбаатар. 2001 он.